

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

/2020 оны жилийн эцсийн байдлаар /

2021.01.12

Дархан-Уул

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий Сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн Газрын албан даалгаврын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 91 шийдвэрийн 182 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланг уншин танилцаж, боловсруулалт, сайжруулалтыг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээллийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хууль эрх зүйн хэлтсийн тухайн асуудлыг хариуцсан албан хаагчдаас тодруулга авах, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр хуралдааны гишүүдээс гарсан саналыг тусгах замаар цуглуулсан нэмэлт мэдээ, мэдээлэлд үндэслэн сайжруулалтыг гүйцэтгэв.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:


- ✓ Монгол Улсын 7 хуулийн 23 заалт,
- ✓ УИХ-ын 1 тогтоолын 1 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 3 тогтоолын 4 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 4 заалт,
- ✓ ҮАБЗ-ийн 3 зөвлөмжийн 8 заалт,
- ✓ Засгийн газрын 53 тогтоолын 94 заалт,

- ✓ Ерөнхий Сайдын 1 захирамжийн 1 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 16 тэмдэглэлийн 23 заалт,
- ✓ Засгийн газрын 5 албан даалгаврын 24 заалт, нийт 91 шийдвэрийн 182 заалтыг хяналтанд аван хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2017-2020 онд хяналтад авсан шийдвэрийн болон заалтын тоог харуулбал:

Он	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ
2017 он	76	107	98.30%
2018 он	84	149	98.00%
2019 он	63	99	94.27%
2020 он	91	182	96.95%
Дундаж	78.5	134.2	96.82%

Дархан-Уул аймгийн хэмжээнд хяналтад авсан шийдвэр, заалтын тоо



Жилд дунджаар 78 шийдвэрийн 134 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

2020 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан 91 шийдвэрээс 23 шийдвэр буюу 25.30 % нь нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан (Ковид-19) Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг үндэслэн Засгийн газраас гаргасан шийдвэрүүд байлаа.

Үүнд:

Д/д	Эрх зүйн актын нэр, дугаар	Заалт	Тайлбар
Монгол Улсын хууль			
1	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29	16.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	

Дугаар 2020.04.29		
Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмж		
2	Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын талаар авах арга хэмжээний тухай 2020-11-13 Дугаар 2020_26/16	1. Дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар /Коюид-19/-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, цар тахлын халдварын тархалтыг зогсоох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг шуурхай зохион байгуулах.
Засгийн газрын тогтоол		
3	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020-02-12 Дугаар 2020_62	3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.
4	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-02-28 Дугаар 2020_78	8. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.
5	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай.
6	2020-03-22 Дугаар 2020_102	5. Тусгаарлалтад хамрагдсан иргэдэд тавих хяналтыг чангатгах, тусгаарлалтын журам зөрчсөн иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцох арга хэмжээ авахыг Цагдаагийн ерөнхий газар (С.Баатаржав), Онцгой байдлын ерөнхий газар (Т.Бадрал) болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.5
7	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-27 Дугаар 2020_114	3.2.Төсвийн урсгал зардлаас дараахь зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх: 3.2.1. бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зардал;3.2.2. бүх шатны төсвийн байгууллагын коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардал; 3.2.3. бүх шатны төсвийн байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан,

		халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал; 3.2.4. нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ.	
8	Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-04-15 Дугаар 2020_139	2. Сургалтын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд боловсролын байгууллагын гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэх зорилгоор шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	
9	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2020-05-06 Дугаар 2020_164	3. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	Давхацсан
10	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2020-05-06 Дугаар 2020_166	2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан эрх бүхий байгууллагаас коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зөвлөмж, шаардлагыг хангасан, зохих зөвшөөрөл бүхий сургалтын төвийн танхимын сургалтыг үе шаттай эхлүүлэх, танхимын сургалтад 16-аас доош насны хүүхдийг хамруулахгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймаг... үүрэг болгосугай.	
11	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай 2020-05-06 Дугаар 2020_167	2. Зочид буудал, жуулчны бааз, амралт, сувиллын үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тусгай горим тогтоож, үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
12	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай 2020-05-06 Дугаар 2020_167	3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ үйлчилгээний байгууллагад үйлчлүүлэгч хоорондын зайг зохистой хэмжээнд тогтоож үйл ажиллагааны цар хүрээ, цагийн хуваарийг оновчтой хэлбэрээр зохион байгуулах, халдвараас урьдчилан сэргийлэх талаар иргэдийн ойлголт, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	
13	Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн	3. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт	

	<p>зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай 2020-05-06 Дугаар 2020_168</p>	<p>оруулах замаар энэ тогтоолын 1 дэх заалтад заасан төсвийн зохицуулалтыг тусган баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй. 3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.</p>	
14	<p>Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2020-05-27 Дугаар 2020_198</p>	<p>3. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулж, ажлын байранд нь тусгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, нөхцөл шаардлага, тусгай горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	Давхацсан
15	<p>Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай 2020-06-01 Дугаар 2020_213</p>	<p>2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, нөхцөл шаардлага, тусгай горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыгаймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.</p>	Давхацсан
16	<p>Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2020-08-05 Дугаар 2020_37</p>	<p>3. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыгаймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.</p>	Давхацсан
17	<p>Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020-09-14 Дугаар 2020_103</p>	<p>3. Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хэвийн горимоор ажиллуулж, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйтгэлийг заавар, зөвлөмжийн дагуу мэргэжлийн байгууллагуудтай</p>	

		хамтран тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтмол зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
18	Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2020-11-04 Дугаар 2020_171	2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор энэ онд Шинэ жилийн баярыг нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд хязгаарласугай. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	
19		6. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, түгээлт, борлуулалтын үйлчилгээг хэвийн явуулах арга хэмжээг Эрүүл мэндийн яамнаас баталсан халдвар хамгааллын дэглэм, горимыг чанд сахиулсны үндсэн дээр авч хэрэгжүүлж, энэ чиглэлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхийг ...аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгаж, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим (О.Амартүвшин)-д зөвлөсүгэй.	
20		18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	
21	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй ^{SEP} холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр ^{SEP} авах зарим арга хэмжээний тухай 2020-11-18 Дугаар 2020_183	19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	
22		20. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл сунгахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	
23		23. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, соён гэгээрүүлж, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх нэвтрүүлэг, контентыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах, нэвтрүүлэх, хүн	

		хооронд 2 метрийн зай барих, амны хаалт тогтмол зүүлгэх, үйлчлүүлэгч, ажилчдын биеийн халууныг тогтмол үзэх, ариутгах бодисыг байршуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр тутам хийх ажлыг зохион байгуулж байхыгаймаг, нийслэлийн Засаг дарга, ...болон холбогдох бусад албан тушаалтанд даалгасугай.	
24	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 2020-11-23 Дугаар 2020_187	2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсвийн хэмнэлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчлэх хугацаанд тухайн салбарын хэмжээнд цар тахалтай тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосугай. Төсвийн зохицуулалтын батлагдсан хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар зохион байгуулж, төсвийн сахилга, хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	
25	Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-11-23 Дугаар 2020_188	1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж улсын хэмжээнд хөл хорионы дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсэнд зарцуулахаар нөөцөлж, төлбөрийг нь бүрэн барагдуулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсролын байгууллагын гаргасан судалгааны дагуу цэцэрлэг, сургуулийн насны хүүхэдтэй, хүнсний дэмжлэг үзүүлэх шаардлагатай зорилтот бүлгийн өрхөд түгээх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	
26		2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд улсын хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр цэцэрлэг, сургуулиас дайчилсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг бодит гүйцэтгэлээр тооцож, холбогдох төсвийн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд тусгаж энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээний хүрээнд өр үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг ...аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.	
27		3. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж, эрүүл ахуй, халдвар	

		хамгааллын дэглэмийг баримтлан, өрхөд түгээх ажлыг зохион байгуулахыг ...аймаг, нийслэлийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	
28		5. Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон аймгийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, халдвар хамгааллын дэглэм, горимыг чанд мөрдөж ажиллахыг дээрх аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
29	Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2020-11-29 Дугаар 2020_194	6. Халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол шинээр бүртгэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.1, 11.3.2-т заасны дагуу холбогдох бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг тухайн шатны онцгой комиссын дарга нарт даалгасугай.	
30		7. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.	
31	Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай 2020-12-09 Дугаар 2020_209	4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэхтэй холбогдуулан халдварын тохиолдол бүртгэгдсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн ажиллах горим, үйл ажиллагааны чиглэл болон иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах хүрээг тогтоож, халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг бүх шатны онцгой комисст үүрэг болгосугай.	
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл			
32	2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 33 дүгээр тэмдэглэл 2020-05-27 Дугаар 2020_33	Х.2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг хүүхдийн тоог, төрийн	

		<p>өмчийн их, дээд сургуулийн дэргэдэх болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухайн хичээлийн жилийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг суралцагчийн тоог үндэслэн тооцож санхүүжүүлэхээр тогтов.</p> <p>2. Хувьсах зардалд шаардагдах санхүүжилтийг 2020 оны батлагдсан төсвийн дүнд багтаан гаргахыг,.... аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох.</p>	
33		<p>ХҮ.3. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулж, ажлын байранд нь тусгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, нөхцөл шаардлага, тусгай горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох.</p>	Давхацсан
34	<p>2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 61 дүгээр тэмдэглэл 2020-11-13 Дугаар 2020_61</p>	<p>I. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа шуурхай хариу арга хэмжээний талаархолбогдох Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав." гэжээ.</p>	
Нийт		23 шийдвэрийн 34 заалт	

Дээрх үүрэг болгосон 23 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилтийг Дархан-Уул аймаг, сумын онцгой комисс, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлага, холбогдох албан тушаалтнууд 100 хувь ханган ажилласан байна.

Гурав. Үнэлгээний дүгнэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2020 оны жилийн эцсийн байдлаар **97.50** хувийн хэрэгжилттэй **4.50** онооны үнэлгээтэй байна

Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Биелэлт	Нийт	Шийдвэрийн төрөл								
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайддын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	91	7	1	3	2	3	53	1	16	5
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	182	23	1	4	4	8	94	1	23	24
3.	Үүнээс										
	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	164	21	-	4	4	7	86	-	19	23
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	10	1	-	-	-	1	6	1	1	-
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	2	1	-	-	-	-	-	-	1	-
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хугацаа болоогүй/ Үнэлэх боломжгүй	6	-	1	-	-	-	-	2	-	2	1
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		97.50% буюу 4.87 оноо	95.65% буюу 4.78 оноо	Хугацаа болоогүй	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	96.25% буюу 4.81 оноо	98.04% буюу 4.90 оноо	70.0% буюу 3.50 оноо	95.23% буюу 4.76 оноо	100% буюу 5.0 оноо

2020 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан шийдвэрийн төрлийг 2017-2019 оны мөн үеийн хяналтад авсан шийдвэрийн төрөлтэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

Он	Заалтын тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайддын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2017	107	0	0	3	4	3	58	0	27	12	0
2018	149	2	3	3	7	3	74	5	24	13	15
2019	99	1	1	3	2	0	60	4	16	8	4
2020	182	23	1	4	4	8	95	1	23	24	0

2020 онд хяналтад авсан Монгол Улсын 7 хуулийг нэршил, заалтын тоогоор нь танилцуулбал:

1. Татварын ерөнхий хууль (2019-03-22) -ийн 2 заалт,
2. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай (2020-04-29) хуулийн 1 заалт,
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ (2020-05-07) хуулийн 4 заалт,
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 хуулийн 12 заалт, (19.1.4-30.0%, 19.1.5-70.0%)
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 хуулийн 2 заалт,

6. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 хуулийн 1 заалт,


7. Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 хуулийн 1 заалт,
нийт 23 заалт-ыг хяналтад авч хэрэгжилтийг 95.65% -иар ханган ажилласан байна.

Холбогдох зохицуулалтын салбараар нь харуулбал:

№	Биелэлт	Нийт	Зохицуулалтын салбар											
			Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал, уул уурхай	Санхүү төлөвлөлт, хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Хамгаалах, гамшгаас урьд.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, дэд бууц, эрчим хүч	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спорт	Зам тээврийн хөгжил	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд	
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	101 давхадсан	9	10	16	5	16	13	9	10	1	9	3	
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	182	28	18	29	7	28	17	16	12	1	20	6	
3.	Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	164	25	15	28	7	24	17	15	11	1	16	5
		Хэрэгжих шатанд 70% (50-89%)	10	1	1	1	-	3	-	1	1	-	2	-
		Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	2	-	1	-	-	-	-	-	-	-	1	-
		Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй/ үнэлэх боломжгүй		6	2	1	-	-	1	-	-	-	-	1	1
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		97.50% буюу 4.84 оноо	98.84% буюу 4.94 оноо	94.11% буюу 4.70 оноо	98.9% буюу 4.94 оноо	100% буюу 5.0 оноо	96.6% буюу 4.83 оноо	100% буюу 5.0 оноо	98.1% буюу 4.90 оноо	97.5% буюу 4.87 оноо	100% буюу 5.0 оноо	93.15% буюу 4.65 оноо	100% буюу 5.0 оноо	

2017-2020 онуудад хяналтад авсан заалтын тоог зохицуулалтын салбараар нь хүснэгт, графикаар харуулбал:

Он / заалтын тоо	Зохицуулалтын салбараар, үүнээс												
	Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Төлөвлөлт, санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлан хамгаалах, гамшгаас урьд.	Барилга хот байгуулалт	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр хөгжил	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд	Уул уурхай	Эрчим хүч
2017 он	25	17	10	6	15	2	7	4	4	5	10	0	1
2018 он	44	18	7	24	18	9	9	5	3	5	6	1	0
2019 он	30	15	2	1	18	6	8	8	4	4	3	0	0
2020 он	28	18	29	7	28	17	0	12	1	20	6	1	2
Дундаж	32	17	12	9	20	8	8	7	3	8	6	1	1.5



Графикаас харвал 2017-2020 онуудад:

1. Байгаль орчин, аялал жуулчлал,
2. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
3. Барилга хот байгуулалт,
4. Зам тээвэр хөгжил,
5. Уул уурхай,
6. Эрүүл мэнд,
7. Эрчим хүчний салбаруудын чиг үүрэгт хамаарах хяналтад авахыг үүрэг болгосон заалтууд харьцангуй тогтвортой байна.

Харин дараах салбаруудын хувьд хяналтад авахыг үүрэг болгосон заалтууд өөрчлөлт ихтэй байсан нь харагдаж байна. Үүнд тухайлбал:

1. Ерөнхий чиг үүрэг,
2. Төлөвлөлт санхүү, хөрөнгө оруулалт,
3. Хууль эрх зүй,
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт,
5. Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын чиг үүрэгт хамаарах хяналтад авахыг үүрэг болгосон заалтууд хамгийн багадаа 6, хамгийн ихдээ 23 заалтын хэлбэлзэлтэй байна.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

1. Хугацаа болоогүй буюу 2021 онд барилгын ажил эхлэхээр тайлагнасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-

- ын 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийг аймгийн НБХэлтэс, аймгийн ХХҮГ-ын холбогдох албан тушаалтнууд хяналтыг тавьж, хамтран ажиллах,
2. Цаг үеийн нөхцөл байдал (Ковид-19)-аас шалтгаалан үнэлэх боломжгүйгээр үнэлэгдсэн
 - Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 3 дахь заалт,
 - Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 183 дугаар тогтоолын 3 дахь заалт,
 - Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2020 оны 02 дугаар албан даалгаврын 1.3 дахь заалтаар өгөгдсөн хяналт шалгалт, сургалтын үйл ажиллагаануудыг цаг үеийн байдлыг харгалзан ТАЗСЗөвлөл, НБХэлтэс, БСУГазар, МТАлба, ХЭЗХэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн холбогдох албан тушаалтнууд анхаарч зохион байгуулах.
 3. Хэрэгжилт хангалтгүйгээр буюу 30%-иар үнэлэгдсэн:
 - 2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр тэмдэглэлийн “ХИ.1. 12. Дархан-Уул аймагт хэрэгжих уул уурхай, металлургын цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор гангийн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар газар ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох арга хэмжээ авахыг Дархан-Уул аймгийн Засаг дарга Н.Насанбат нарт” нэр зааж үүрэг болгосон,
 - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 19.1.4 “Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”-аар үүрэг болгосон 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ХЭЗХ-ийн холбогдох албан тушаалтнууд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах,
 4. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс, НБХэлтсүүдийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүд аймгийн МХГазар, ХХААГазар, БСУГазруудаас ирүүлсэн тайлангаас гол үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан боловсруулалт хийж байх,
 5. Мэргэжлийн хяналтын, боловсролын болон хөдөө аж ахуйн салбарын зарим заалтын хэрэгжилтүүд хэт дэлгэрэнгүй байх тул шаардлагатай гэж үзвэл тайлан, фото зургийг тусгайлан ирүүлэхийг тус тус зөвлөж байна. Жишээ нь:
 - Засгийн газрын 2019 оны 104 тогтоол “1.16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих” ХОХБТХ, МХГ
 - 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэлийн ХҮ1.5.1. /цэцэрлэг/ НБХ, БСУГазар
 - “Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоол 2019-05-01 Дугаар 2019_185 ХОХБТХ, ХХААГазар,
 - Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол 2020-01-15 Дугаар 2020_18 ХОХБТХ, ХХААГазар,

- 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Засгийн газрын хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2018-04-25. Дугаар 2018_18 ХОХБТХ, ХХААГазар,
- “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын албан даалгавар 2019-05-01. Дугаар 2019_02 ХОХБТХ, ХХААГазар.

Тав. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:

Дархан-Уул аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрээр ХОХБТХ-ийн дарга П.Батсүхийн хэлсэн саналын дагуу Засгийн газрын 2020 оны 33 дугаар тэмдэглэлийн XI.3 “Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн орон тоог баталж, цалин, үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх, цаашид жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг” үүрэг болгосон заалт нь манай аймагт хамаарахгүй гэсэн тайлбарыг өгсөн тул нэмж орууллаа.

2020 онд нийт 25 шийдвэрийн 34 заалтыг цахим сангийн хяналтаас хасуулах тухай саналыг тайлбарын хамт тэмдэглэж, орууллаа. Энэ нь нийт заалтын 18.68%-ийг эзэлж байна.

Хяналтнаас хасах саналын тоог 2017-2019 онуудын мөн үеийн саналын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хасах санал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
2017 он	12	15
2018 он	25	34
2019 он	18	21
2020 он	25	34
Дундаж, тоо	20	26

Цахим сангийн хяналтнаас хасуулах санал өгсөн шийдвэр, заалтын тоо



Дэлгэрэнгүйгээр үзүүлбэл:

Д/Д	ШИЙДВЭР	ЗААЛТ	ТАЙЛБАР
САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ			
1.	Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149	1. Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Үйл ажиллагаа тогтмолжсон тул цахим сангийн хяналтнаас хасах
2.	Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 2017-07-03 Дугаар 2017_276	3. Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж хэвшсэн тул хасах
3.	Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2020-11-04 Дугаар 2020_171	2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2020 онд Шинэ жилийн баярыг нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд хязгаарласугай. 2. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	1 удаагийн шинжтэй тул цахим сангийн хяналтнаас хасах
4.	2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2020-03-27 Дугаар 2020_21	III.3. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов: 2.1. үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх.	Хэрэгжилтийг тооцуулсан тул цахим сангийн хяналтнаас хасах
4 шийдвэрийн 4 заалт			
САЛБАР ЧИГЛЭЛ: 3 БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ			
5.	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2020-08-25 Дугаар 2020_72	2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Бүрэн хэрэгжсэн, жил бүр шийдвэр гардаг тул хасах
6.	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020-02-12 Дугаар 2020_62	3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.	Засгийн газрын 149, 209 дүгээр тогтоолууд мөрдөгдөж байгаа тул хяналтнаас хасах
7.	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай / 2020-05-06 / Дугаар 2020_164.	3. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыгаймаг, нийслэлийн	Давхардсан байх тул хасах /Засгийн газрын 2020.05.27, 2020.06.01, 2020.08.05-ны өдрийн тогтоолууд/

		Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	
3 шийдвэрийн 3 заалт			
САЛБАР ЧИГЛЭЛ: 4 САНХҮҮ, ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ			
8.	Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01	8.1. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.	Бүрэн хэрэгжсэн, хэвшсэн тул хяналтнаас хасах
9.		8.5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.	Бүрэн хэрэгжсэн, хэвшсэн тул хяналтнаас хасах
10.	Аргачлал шинэчлэн батлах тухай 2019-12-18 Дугаар 2019_445	2. Аргачлалыг баримтлан орон нутгийн төсвийн төслийг боловсруулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, аймаг, нийслэлийн төсөвт шилжүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тухай бүр тогтоож байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт тус тус үүрэг болгосугай. 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай" Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.	Жил бүрийн төсвийн төслийг боловсруулахдаа мөрдлөг болгон хэвшсэн тул хасах
11.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01	9.2.2. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх урт болон богино хугацааны хөтөлбөр батлах; (9.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн ИТХ-ын бүрэн эрх тул хасах саналтай
12.		9.2.4. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах, төлбөрийн хувь хэмжээг тогтоох. (9.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн ИТХ-ын бүрэн эрх тул хасах саналтай
13.	2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 2 дугаар тэмдэглэл 2019-01-09 Дугаар 2019_2	ХХIII.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.1.2-т заасны дагуу олон нийтийн цагдаагийн ажилтан харьяа нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, иргэдэд сурталчлахад дэмжлэг үзүүлж, гэмт хэрэг, ослын гаралтыг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Үйл ажиллагаа тогтмолжсон тул цахим сангийн хяналтнаас хасах
4 шийдвэрийн 6 заалт			
САЛБАР ЧИГЛЭЛ: 6 ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ			
14.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.3. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах;	Аймгийн ИТХ-ын бүрэн эрх, бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай
15.		19.1.2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;	Үйл ажиллагаа тогтворжсон тул хасах
16.		19.1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Бүрэн хэрэгжсэн тул хасах
17.		19.1.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг	Бүрэн хэрэгжсэн тул хасах

		харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	
18.	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2020-05-27 Дугаар 2020_198	3. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулж, ажлын байранд нь тусгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, нөхцөл шаардлага, тусгай горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Давхардсан байх тул хасах ЗГТогтоол 2020.05.06 2020.05.27 2020.06.01 2020.08.05
19.	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай 2020-06-01 Дугаар 2020_213	2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, нөхцөл шаардлага, тусгай горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыгаймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	
20.	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2020-08-05 Дугаар 2020_37	3. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыгаймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох зардлыг зохих журмын дагуу хариуцахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	
21.	2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 33 дүгээр тэмдэглэл 2020-05-27 Дугаар 2020_33	ХҮ.3. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулж, ажлын байранд нь тусгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, нөхцөл шаардлага, тусгай горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыгаймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох.	
5 шийдвэрийн 8 заалт			
САЛБАР ЧИГЛЭЛ: 7 ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ДЭД БҮТЭЦ, ЭРЧИМ ХҮЧ			
22.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан үйлчлэх хугацаанаас зургаан сарын өмнө батална.	Бүрэн хэрэгжсэн тул хасах
23.		17.4. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.	Бүрэн хэрэгжсэн тул хасах

24.		18.6. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.	Бүрэн хэрэгжсэн тул хасах
25.		21.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Үйл ажиллагааг мөрдөж хэвшсэн тул хасах
26.	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	16.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл дэх дайчилж болох барилга байгууламжийн жагсаалтыг гаргаж Улсын онцгой комисст хүргүүлнэ.	Бүрэн хэрэгжсэн тул хасах
2 шийдвэрийн 5 заалт			
САЛБАР ЧИГЛЭЛ: 8. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТ			
27.	Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай 2020-05-27 Дугаар 2020_195.	2. Хувьсах зардалд шаардагдах санхүүжилтийг 2020 оны батлагдсан төсвийн дүнд багтаан гаргахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Бүрэн хэрэгжсэн тул хяналтнаас хасах
28.	Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-11-23 Дугаар 2020_188	2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд улсын хэмжээнд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр цэцэрлэг, сургуулиас дайчилсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг бодит гүйцэтгэлээр тооцож, холбогдох төсвийн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд тусгаж энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээний хүрээнд өр үүсгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг... аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.	Бүрэн хэрэгжсэн тул хасах
29.	2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл Дугаар 2017_36	ХҮҮ.5.1. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов: 1.1. цэцэрлэгийн зориулалттай болон цэцэрлэгийн зориулалтаар тохижуулсан барилга байгууламжтай, хүний нөөцийн болон сургалтын орчны стандартыг хангасан сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг судалж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шуурхай олгох ажлыг зохион байгуулах; 1.2. төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг нээн ажиллуулах, өргөтгөх талаар гаргаж байгаа санал, санаачилгыг бүхий л талаар дэмжих;	Дотоодын хяналтанд авч, цахим сангийн хяналтнаас хасуулах
30.	2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 33 дүгээр тэмдэглэл 2020-05-27 Дугаар 2020_33	Х.2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг хүүхдийн тоог, төрийн өмчийн их, дээд сургуулийн дэргэдэх болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол,	Бүрэн хэрэгжсэн тул хасах

		сургалтын байгууллагын тухайн хичээлийн жилийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг суралцагчийн тоог үндэслэн тооцож санхүүжүүлэхээр тогтов. 2. Хувьсах зардалд шаардагдах санхүүжилтийг 2020 оны батлагдсан төсвийн дүнд багтаан гаргахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох.	
4 шийдвэрийн 4 заалт			
САЛБАР ЧИГЛЭЛ: 10 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭР			
31.	2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 33 дүгээр тэмдэглэл 2020-05-27 Дугаар 2020_33	XI.3. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн орон тоог баталж, цалин, үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх, цаашид жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох.	Манай аймагт хамаарахгүй тул хасах
САЛБАР ЧИГЛЭЛ: 11. ЭРҮҮЛ МЭНД			
32.	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016_04	2.1. хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Үйл ажиллагаа тогтмолжсон дотоодын хяналтандаа авах, цахим сангийн хяналтнаас хасах
33.	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-05-01 Дугаар 2019_183	2. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дэргэд өөрийн санхүүжилтээр цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжиж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Үйл ажиллагаа тогтмолжсон, цахим сангийн хяналтнаас хасах
34.		4.Шинээр барих орон сууцны хорооллын барилгын ажлын холбогдох зөвшөөрлийг олгохдоо сургууль, цэцэрлэгийн хамт төлөвлөн барих талаарх барилгын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг мөрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Үйл ажиллагаа хэвшсэн тул хасах
2 шийдвэрийн 3 заалт			
Нийт 25 шийдвэрийн 34 заалт			

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН